# ЦАХИМ ГАРЫИ ҮСГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*Э.Золбоо*
*ДХИС-ийн ЭЗНУС-ийн НЭЗТ-ийн багш,*
*цагдаагийн ахмад*

***Товч агуулга:*** Энэхүү судалгаагаар эрх зүйн зохицуулалтын асуудлыг хууль зүйн, мэдээллийн технологийн болон хууль зүйн практикийн үүднээс судлан тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, сайжруулахад чиглэгдсэн судлаачийн дүгнэлт, үзэл баримтлалыг илэрхийлэхэд зорилго чиглэгдсэн болно.

***Түлхүүр үгс:*** Цахим гарын үсэг, хэрэгжилт, интернэт орчин, эрх зүй, иргэд

## Оршил

Хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн ТОМ ОЛОЛТ ДЭВШЛҮҮДИЙН нэг нь интернэт билээ. АНУ-д анх үүссэн интернэт сүлжээ нь өнөөдөр дэлхий даяар олон арван сая компъютерыг холбосон аварга том сүлжээ бий болсон байна. Манай улсын тухайд 1992 онд Цахилгаан холбооны салбарт технологийн шинэчлэлт хийж, аналог системийг тоон технологиор сольсноор шилэн кабелын сүлжээ үүсэж, интернэт хөгжих таатай нөхцөл бүрдсэн гэж болно. 1994 онд Монгол улс Интернэтэд холбогдож, Датаком компани 1996 онд интернэтийн сүлжээ оруулж ирснээр Монголын интернэтийн хөгжлийн суурь үндэс тавигдсан юм. Ийнхүү интернетийн хэрэглээ үүсэн бий болж, өнөөдөр дэлхийн чиг хандлагад нийцэн хөгжиж байна. Интернетийн хэрэглээ өргөжиж, түүнийг даган технологийн дэвшил хурдацтай өрнөж нийгэм, эдийн засагт томоохон нөлөө үзүүлэх болжээ. Интернет сүлжээ өргөжсөнөөс хойш судлаачдын анхаарлыг төвд байгаа судалгааны объектуудын нэг бол цахим гарын үсгийн тухай ойлголт, түүний эрх зүйн зохицуулалт билээ. Энэ нь зүй ёсны хэрэг бөгөөд цахим худалдаа, захидал харилцаа.мэдээлэл солилцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг дэвшилттэй олон зүйл байгаа боловч нөгөө талдаа мөн цахим орчинд хүний эрх, эрх чөлөө, хуулийн хэм хэмжээг зөрчих явдал нэлээд тулгардаг.

## Нэг. Цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ

Монгол Улсын цахим орчны харилцааг зохицуулах талаар Цахим хөгжил харилцаа, холбооны яамыг шинээр байгуулсан ба түүнтэй холбогдуулан цахим гарын үсэг болон бусад цахим хэрэглээг нэвтрүүлэх энэ талаар судлах хэрэгцээ, шаардлага гарч байгаа юм.

Монгол Улсын “Цахим гарын үсгийн тухай хууль”[1] 2011 оны 12 сарын 15 өдөр батлагдан, хэрэгжиж байсан ба 2012 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Тус хуулийн үзэл баримтлал нь дараах байдлаар гарсан байна:

[1] Цахим гарын үсгийн тухай хууль. 2011 он

1. Цахим гарын үсгийг бүтээх, хамгаалах, ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх
2. Албан хэрэгцээндээ хэрэглэж буй файл, и-мэйлийг албан ёсны мэдээлэл гэж үзэх;
3. Одоогийн интернэт орчинд хийж буй ажлыг хүчин төгөлдөр гэж үзэх боломжийг бүрдүүлэх;
4. Төрийн үйл ажиллагааг илүү хялбар, чирэгдэлгүйгээр иргэддээ хүргэх зорилготой юм.

Цахим гарын үсгийн хууль батлагдсантай холбоотойгоор зарим салбарын хууль тогтоомжинд дараах өөрчлөлтүүд орж цахим гарын үсгийн хууль хэрэгжих эрх зүйн орчинг бүрдүүлж байна.[2] Үүнд:

1. Иргэний хууль;
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
3. Татварын ерөнхий хууль;
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;
5. Иргэний бүртгэлийн тухай хууль;
6. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
7. Захиргааны хариуцлагын тухай хууль зэрэг болно.

Дээрх хуулиудын нэмэлт, өөрчлөлт цахим гарын үсгийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үйлчилж эхэлсэн юм. Эдгээр нэмэлт, өөрчлөлт орсон хуулиудаас Харилцаа холбооны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиуд нь цахим гарын үсгийг хэрэгжүүлэгч байгууллагуудын дотоод үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтүүд байсан.

Харин дараах хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдэд цахим гарын үсгийг иргэд хэрхэн хэрэглэж болохыг илүү тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, Интернэт ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор “Иргэний хууль”-д хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлээс бусад, хуульд бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно гэж нэмэлт, өөрчлөлт оруулсан нь цахим хэлбэрээр хийсэн хэлцлийн талаар маргаан гарсан тохиолдолд шүүхэд хандаж, эрхээ хамгаалуулах боломжийг талуудад олгосон ач холбогдолтой зохицуулалт болсон.

Монгол Улсын Иргэний хууль[3]-д нэмэлт өөрчлөлт оруулж цахим худалдаа эрхлэх ерөнхий нөхцлийг бүрдүүлсэн юм. Монгол Улсын хувьд цахим хэлцлийг тайлбарлаж зохицуулсан эрх зүйн акт одоогоор байхгүй бөгөөд тус асуудал Иргэний хуулийн дагуу зохицуулагдаж байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1-д Тэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө

[2] Дэлгэрэнгүйг Төрийн мэдээлэл сэтгүүл. №1/718/., УБ хот 2012 он
[3] Төрийн мэдээлэл сэтгүүл. №1 /718/УБ хот 2012 он

тодорхойлох эрхтэй” мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т “Хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал нь хүлээн авсан" тохиолдолд хэлцлийг бичгээр хийсэн гэж үзэх, 196 дугаар зүйлийн 196.1.2-т Тэрээг бичгээр байгуулахаар хуульд заасан буюу талууд тохиролцсон бол талууд нэг баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурах буюу гэрээний саналыг зөвшөөрснөө илэрхийлсэн тал гарын үсгээ зурсан захидал, албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал нь хүлээн авснаар” гэрээ байгуулсанд тооцно.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Иргэний хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцэл /гэрээ/-ээс бусад, хуульд бичгээр хийхээр заасан хэлцэл /гэрээ/-г цахим хэлбэрээр хийж болно” гэснээс үзвэл цахим гарын үсэг ашиглаж худалдах, худалдан авах гэрээ байгуулах, хэлцэл хүчин төгөлдөр болох эрх зүйн үндсийг тодохойлсон байна. Цахим гэрээ байгуулахад бусад төрлийн гэрээнээс ялгарах хэд хэдэн онцлогтой. Үүнд:

1. Цахим хэлцэл нь бусад төрлийн гэрээг бодвол цаасан хэлбэрээр бус техник, технологи ашиглаж байгуулдаг;
2. Гэрээний талууд цахим гарын үсэг ашиглан гэрээг баталгаажуулдаг;
3. Талууд гэрээг хадгалах хэлбэр нь өөр байж болдог. Өөрөөр хэлбэл, бичмэл хэлбэрийн гэрээг талууд тус бүр авч хадгалдаг бол цахим гэрээг цахим хэлбэрээр хадгалдаг;
4. Цахим гэрээнд хоёр тал, олон тал оролцож болно. Жишээлбэл, худалдагч, худалдан авагчаас гадна тээвэрлэгч, зуучлагч гэх мэт;
5. Орчин үеийн техник технологийг ашиглан төлбөр тооцоо хийгддэг[4].

Цахим гэрээ нь бусад төрлийн гэрээтэй дараах шинжээрээ төстэй байна. Үүнд:

1. Гэрээ нь маш тодорхой, хоёрдмол утга агуулаагүй байх;
2. Энгийн ойлгомжтой байх;
3. Гэрээний зүйл, үнэ, хугацаа, төлбөр тооцоо, маргаан шийдэрлэх аргын талаар талууд гэрээ байгуулахаас өмнө урьдчилан мэдсэн байна[5].

Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1-д Тэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй”. Мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т “Хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал, цахилгаан, албан бичиг, телефакс эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал нь хүлээн авсан” тохиолдолд хэлцлийг бичгээр хийсэн гэж үзэх, 196 дугаар зүйлийн 196.1.2-т Тэрээг бичгээр байгуулахаар хуульд заасан буюу талууд тохиролцсон бол талууд нэг баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурах буюу гэрээний саналыг зөвшөөрснөө илэрхийлсэн тал гарын үсгээ зурсан захидал, албан бичиг, телефакс

[4] Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт судалгааны ажлын тайлан. УБ хот 2012 он., 50 дахь тал
[5] Рассолов. И. М. Информационное право. Учеб, 2011. С.300.

эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал нь хүлээн авснаар” гэрээ байгуулсанд тооцно.

Өөрөөр хэлбэл, гэрээний нэг тал гэрээ байгуулах хүсэл зоригоо уламжлалт хэлбэрээр гаргаж, хүсэл зоригийг хүлээн авагч тал хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа цахим хэлбэрээр хариу өгч болно. Энэ тохиолдолд гэрээний санал offline хэлбэрээр, саналын хариу нь online хэлбэрээр хэлбэржсэн боловч гэрээ цахим хэлбэрээр байгуулагдсан гэж үзнэ.

Харин гэрээний нэг тал гэрээ байгуулах тухай саналаа цахим хэлбэрээр бусдад илгээсэн, гэрээний нөгөө тал гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн тухайгаа уламжлалт хэлбэрээр илэрхийлсэн бол гэрээг интернэтээр байгуулсан гэж үзэхгүй.

Монгол Улсын хувьд цахим хэлцлийг тайлбарлаж зохицуулсан эрх зүйн акт одоогоор байхгүй бөгөөд тус асуудлыг Иргэний хуулийн дагуу зохицуулагдаж байна.

Бусад зарим улс орнууд цахим хэлцлийн тухай тусгайлсан хуультай байдаг бөгөөд тухайлбал, Оросын Холбооны Улс “Цахим хэрэгсэл ашиглан гэрээ байгуулах тухай хууль”-тай. Энэ хууль нь цорын ганц цахим худалдааг зохицуулсан хууль биш бөгөөд сүлжээ ашиглан гэрээ байгуулах бүхий л боломжийг зохицуулсан.

Өөрөөр хэлбэл, олон төрлийн гэрээг сүлжээ ашиглан хийж болох эрх зүйн үндсийг тодорхойлсон. Үүний сонгодог жишээ бол интернэт банкны үйлчилгээ юм.

Мөн ОХУ-д Цахим худалдааны тухай хууль байдаг бөгөөд хуулийн 5 дугаар зүйлд зааснаар хувь хүн, хуулийн этгээд нь өөрийн хүсэл сонирхолоо илэрхийлэн цахим худалдааны салбарт эрх, үүрэг хэрэгжүүлж болохоор заасан нь түүний хууль зүйн хүчин чадлыг хүлээн зөвшөөрсөн жишиг болно.

Харин тухайн харилцаанд оролцогч субъектүүдийн хувьд цахим худалдаа хийхэд хэд хэдэн зүйлийг анхаарах нь зүйтэй. Тухайлбал,

- Гэрээ байгуулж буй субъект нь уг мэдээллийн сүлжээг ашиглах бүрэн эрхтэй эсэх;
- Гэрээ байгуулах эрх зүйн чадвар, чадамжтай эсэх;
- Өөрийн хүсэл зоригийн дагуу гэрээ байгуулж буй эсэх зэрэг асуудлууд юм.

Домайн нэр буюу “.mn” хаяг газар нутгийн харъяаллыг тодорхойлж болох уу? Хэрэв энэ домайн хаяг кибер орчинг уламжлалт буюу газар зүйн байршилтай адилтгах боломж олгож байгаа тохиолдолд маргаан шийдвэрлэх харъяаллалыг Монгол улсын шүүх гэж тодорхойлж болох уу гэсэн асуудалд судлаач Ц.Нямхүү “Домайн нэрний маргааныг Монголын хувьд шийдвэрлэсэн тохиолдол байхгүй” хэмээн тэмдэглэн энэ төрлийн маргаан гарахад шийдэх магадлан итгэмжлэгдсэн арбитрын байгууллага Монгол Улсад байхгүй тул энэ чиглэлээр мэргэшсэн гадаадын арбитрт хандах, эсвэл шүүхэд хандах арга зам бий гэжээ. Түүнчлэн тэрээр Монголын Худалдаа аж Үйлдвэрийн дэргэдэх Үндэсний арбитрыг олон улсын домайн нэр болон үндэсний домайн нэртэй холбоотой маргаан шийдвэрлүүлэх чиглэлээр магадлан итгэжлүүлэх алхам хийх хэрэгтэй хэмээн дүгнэсэн байна.

**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн** 15 дугаар зүйлийн 15.16.4 дэх хэсэгт зааснаар Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр тоон гарын үсгийн гэрчилгээ олгохоор хуульчилсан. Түүн гарын үсгийн гэрчилгээ олгох гэдэг нь тоон гарын үсгийн гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага, түүний баталсан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд уг тусгай зөвшөөлийг олгохоор зохицуулсан. Уг зохицуулалт орсноор нийтийн түлхүүрийн дэд бүтцэд нэвтрэх эрх олгох, түүнчлэн тоон гарын үсгийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор **“Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль[6]”-д:**

1. Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллага цахим хэлбэрээр шалгаж баталгаажуулна;
2. Хуулийн этгээдийн цахим хэлбэрээр улсын бүртгэлд бүртгүүлж болно;
3. Иргэн, хуулийн этгээд улсын бүртгэлийн жагсаалтаас цахим хэлбэрээр лавлагаа авах хүсэлтийг холбогдох бүртгэх байгууллагад гаргаж болно гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан нь иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулсан ач холбогдолтой зохицуулалт болсон.

Мөн төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй болгох зорилгоор **“Иргэний бүртгэлийн тухай хууль[7]”-д** иргэд лавлагааг цахим хэлбэрээр авч болно, мөн хүүхдийн төрснийг цахим хэлбэрээр бүртгүүлж болно гэж тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан нь иргэдийн цагийг хэмнэсэн ач холбогдолтой зохицуулалт болсон юм. Түүний хэрэгжилтийн нэг илрэл нь Төрийн үйлчилгээний цахим машин буюу ТҮЦ машиныг ашиглалтанд оруулж, иргэдэд төрийн цахим үйлчилгээг хүргэж эхлээд байна.

2013 оны 6 сарын 19-өөс ТҮЦ машинаас иргэд 18 нэр төрлийн үйлчилгээ авч эхэлсэн бөгөөд Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх талаархи лавлагаа авч, Иргэний үнэмлэхээ захиалж авах нөхцлийг бүрдүүлснээр нийт 20 төрлийн үйлчилгээг авч байна[8]. Төрийн үйлчилгээний цахим машиныг нэтрүүлснээр:

Хөдөө орон нутагт амьдарч буй иргэдэд Төрийн үйлчилгээг ойртуулах, хүргэх ба улс орны аль ч хэсэгт иргэн төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай авах боломж

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, түргэн шуурхай болгосноор тухайн үйлчилгээнд зарцуулах цаг хугацаа, эдийн засгийн хувьд үргүй зардлыг багасгах

Иргэд хэзээ ч өөрийн хэрэгцээт төрийн үйлчилгээний авах боломжийг бүрдүүлэх

Төрийн үйлчилгээнээс бусад төрлийн үйлчилгээг мөн хөдөө орон нутагт амьдарч буй иргэдэд хүргэх боломжийг нэмэгдүүлэх

[6] Төрийн мэдээлэл сэтгүүл. №1/718/.
[7] Төрийн мэдээлэл сэтгүүл. №1/718/
[8] www.tutsmashin.mn

Төрийн үйлчилгээний талаархи санал гомдолыг цаг алдалгүй төрийн шийдвэр гаргах албан тушаалтанд хүргэх нөхцлийг тус тус бүрдүүлсэн.

Төрийн үйлчилгээний цахим машинаас олгогдох үйлчилгээ нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт ашиглагддаг QR кодоор баталгаажсан нууцлалтай цаасан дээр хэвлэгдэх бөгөөд ямар нэгэн байдлаар дуурайлгах, хуулбарлах боломжгүй юм. “ТҮЦ машин” нь төрийн бүхий л төрлийн боломжит үйлчилгээг хүргэх бөгөөд эхний байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн лавлагаа, Татварын Ерөнхий газрын 4 төрлийн лавлагаа болон ААН-үүдийн үйлчилгээг хүргэнэ. Үүний дотор өдөр тутмын сонингуудын захиалга, цахилгааны төлбөрийг ч “ТҮЦ машин”-аар дамжуулан төлөх боломж бүрдэж байна.

Түүнчлэн банкны үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-д мөнгөн хадгаламжийн гэрээг цахим хэлбэрээр хийж болно, иргэн хуулийн этгээд цахим хэлбэрээр данс нээлгэж, хаалгаж болно гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь орсноор иргэд цахим банкны үйлчилгээнд бүртгүүлэх, данс нээлгэх, мөнгөн шилжүүлэх хийх, дансны үлдэгдэл, орлого, зарлагаа бүрэн хянах, цахим зээлийн үйлчилгээ зэрэг банкны бүхий л үйлчилгээг хүссэн цагтаа авч цаг хугацааг хэмнэх боломжтой болсон. Эдгээр төрийн үйлчилгээг авахдаа иргэд ТҮЦ машинаас гаргасан баримт бичигтээ өөрийн цахим гарын үсэгээ зурж баталгаажуулдаг байх, илгээдэг байх зэрэгээр илүү хялбарчлах боломж бий юм.

**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн** 15 дугаар зүйлийн 15.16.4-т зааснаар “тоон гарын үсгийн гэрчилгээ олгох[9]” гэж заасан. Уг нэмэлт өөрчлөлтөөр тоон гарын үсэг баталгаажуулах эрх бүхий хуулийн этгээд нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагыг тусгаж өгсөн. Энэ нь хууль зүйн агуулгаараа нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах, хамгаалах, цахим гарын үсгийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

2011 оны 12 дугаар сарын 15 өдрийн 61 дүгээр УИХ-ын тогтоолоор “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” баталсан байх ба үүнд төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх болон Монгол Улсын насанд хүрсэн иргэн бүрд тоон гарын үсгийн түлхүүрийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болгох нөхцөлтэй шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол улсын ЗГ-т даалгасан байна. Энэхүү урьдчилсан бэлтгэл ажлын нэг нь болж Татварын ерөнхий газар аж ахуйн нэгж байгууллагын татварын тайланг тоон гарын үсэг ашиглан цахим хэлбэрээр авч эхлээд байгаа бөгөөд Татварын ерөнхий газрын даргын 2011 оны 671 дугаар тушаалаар батлагдсан *"Тоон гарын үсгийн технологийн дүрэм”-ийг* мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.

Мөн дараагийн чухал эрх зүйн эх сурвалж бол “Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль” юм. Иргэн өөрийнх нь мэдээллийг хэн харж байгааг мэдэх эрхтэй. Өөрийн ямар мэдээлэл төрд байгаа вэ гэдгээ ч мэдэх ёстой. Нэг тод жишээ бол шинэ гэр бүл болсон хосуудад төрөөс 500 мянган төгрөгийн тэтгэмж өгч байх

[9] Төрийн мэдээлэл сэтгүүл. №1

үед ангийнхаа охинтой гэрлэлтээ батлуулаад мөнгөө аваад тухайн үедээ хэрэглэчихсэн залуу өнөөдөр жинхэнэ гэр бүлээ батлуулах болтол өмнөх гэрлэлтээ цуцлуулах шаардлага үүсдэг бөгөөд гэрлэлтээ бүртгүүлсэн охиныг олохгүй байгаа тухай хүсэлтүүд олон орж ирдэг. Энэ бол тухайн иргэн төрд байгаа өөрийн мэдээллээ мэдэхгүй байгаатай холбоотой. Эргээд төр өөрт байгаа мэдээллээ иргэнд өгөхийн тулд иргэнээс мөнгө авч болохгүй гэсэн үндсэн чиглэл баримталж байгаа. Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулиар мэдээллийг боловсруулах, мэдээллийг нь хэрхэн ашиглаж байгааг мэдэх, хянах эрх зүйн үндэслэлтэй болж байгаа юм.

Харин нийтийн мэдээллийн хууль нь төрд байгаа дата, мэдээллийг боловсруулах, ашиглах тухай эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. Өнөөдөр бид мэдээллээ ашиглаж огт чадахгүй байгаа. Дата, мэдээлэл маш их байна. Үүнийгээ боловсруулж, бүтээгдэхүүн гаргахдаа ашиглаж чадахгүй байна. Дата нь дэлхий дээрх хамгийн үнэтэй валют болоод байна. Нээлттэй мэдээллийг боловсруулж, бизнест ч ашиглах боломж бий.

Түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль сүүлийн 15 жилийн хугацаанд яригдсан ч батлагдаагүй өнөөг хүрчээ. Өнөөдөр бид зайлшгүй энэ хуулийг баталснаар, иргэдийнхээ мэдээллийг цахим орчинд хамгаалах хууль эрх зүйн үндэс бүрдэх юм.

Эдгээр 3 хууль бол салбарын эрх зүйн зохицуулалтад зайлшгүй байх ёстой шинэ хуулиуд юм. Дээрхээс гадна 2013 онд анх батлагдсан тоон гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль байдаг. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр олон иргэнийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хууль эрх зүйн хүрээнд хүчин төгөлдөр гэж үзэх хуулийн үндэслэлийг баталгаажуулах юм.

**Хоёр. Цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ**

Монгол Улсын нийгмийн амьдралын бүхий л салбарт мэдээллийн технологи эрчимтэй нэвтэрч үйл ажиллагаандаа ашиглах болсноор цахим хэлбэрээр өгөгдөл дамжуулах, солилцох, хүлээн авахтай холбоотой хүндрэлүүд тулгарч байгаа билээ. Монголын интернет хэрэглэгчдийн тоо 1 саяд дөхөж, цахим бизнес, банкны үйлчилгээнд бүртгүүлсэн, үйлчилгээ авдаг хүмүүс 300000 хүрч, цахим гааль, цахим татварын үйлчилгээ авдаг хувь хүмүүс, хуулийн этгээдийн тоо 200000-д хүрсэн.

Мөн төрийн болон бизнесийн байгууллагууд, хувь хүмүүс хоорондын харилцаа, цахим баримт бичиг, өгөгдөл солилцохдоо интернетийг өргөн ашигладаг болсон.

Интернетээр хоорондоо харилцахад бие биеэ харах боломжгүй учраас цахим хэлбэрээр дамжуулж буй зүйлийн аюулгүй байдлыг хангах, үнэн зөвийг баталгаажуулах, бие биеэ таньж баталгаажуулах зайлшгүй шаардлага тулгардаг. Үүнийг шийдэх хэрэгсэл нь цахим тоон гарын үсэг билээ. Цахим хэлбэрээр өгөгдөл солилцох нь цаасан тээгч дээрх мэдээлэл солилцохоос эрс ялгаатай ба ажил хэргийн харилцаа, төрийн удирдлагад цахим хэлбэрээр өгөгдөл, баримт бичиг солилцох ажиллагааг нэвтрүүлснээр маш олон давуу тал, хэмнэлт

гардаг боловч түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах, илгээсэн этгээдийг мөн эсэхийг адилтган тогтоох асуудал урган гардаг. Энэ асуудлыг тоон гарын үсгийн хэрэгслүүд ашиглах замаар шийддэг юм.

Манай улс мэдээлэл, харилцаа холбооны технологийг нийгмийн бүхий л хүрээнд нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж 2004 онд үндэсний хэмжээний хөтөлбөр баталсан[10] байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012) хөгжлийн бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолоор[11] "Цахим гарын үсгийн тухай хууль"-ийг шинээр боловсруулж, батлуулахаар болсон нь дээрх хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлын нэг байсан юм. "Цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нь цаасан тээгч дээрх баримт бичиг солилцохоос эрс ялгаатай.

Монгол Улсын хувьд цахим харилцаа, худалдаа, үйлчилгээний харилцаа эрх үүссэн ч барууны улсуудтай харьцуулбал мэдээлэл холбооны технологи, дэд бүтэц сул хөгжсөн, эрх зүйн зохицуулалт хангалттай бус, тухайлбал, мэдээллийн аюулгүй байдлын тухай, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах шаардлагтай байна. Мөн цахим худалдааны талаарх олон нийтийн мэдлэг сул, Монгол Улсын гадаад худалдааг хөгжүүлэхэд цахим худалдааны үзүүлж буй нөлөөлөл байхгүй, интернет үйлчилгээний импорт байнга нэмэгдэж байгаа, аж ахуйн нэгж байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлын талаар ойлголт муу, гэрээ байгуулж буй субъект нь уг мэдээллийн сүлжээг ашиглах бүрэн эрхтэй эсэх, гэрээ байгуулах эрх зүйн чадвар, чадамжтай эсэх, өөрийн хүсэл зоригийн дагуу гэрээ байгуулж буй эсэх зэрэг асуудлууд тулгамдсан асуудал болж байна.

Дэлхийн улсуудад тоон гарын үсгийн хэрэглэх асуудлыг 1990 оноос эхлэн хуульчилсаны нөлөөгөөр цахим худалдаа нь даяаршлын далайцтай жишээ болж, түргэцтэй хөгжиж байна. Цахим худалдаанд техник, эдийн засаг, нийгэм ба соёлын зэрэг олон талын асуудал холбогдоно. Эдгээр асуудлыг тусгаж, бүхэлд нь авч үзэх, эрх зүйгээр зохицуулах шаардлага гардаг. Тухайлбал, цахим хэлбэрээр хийгдсэн арилжаа хүчинтэй байх асуудал, түүнээс урган гарах хууль зүйн үр дагавар зэрэг чухал ойлголтуудыг дурдаж болно. Цахим арилжааны эрх зүйн бусад асуудал мэдээллийг хамгаалах, татвар төлөх, гаалийн татвар ногдуулах, аюулгүй байдлыг хангах, оюуны өмчийн эрхийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, маргаан шийдвэрлэхтэй холбоотой асуудлууд болон интернет үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хариуцлага, хууль бус үйлдэл болон гэмт хэрэг, интернетийн засаглал, цахим арилжаа явуулах төлбөр тооцооны тогтолцоо зэрэгтэй холбоотой асуудлууд багтана[12] гэж үзсэн байна.

[10] Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын "Электрон Монгол" хөтөлбөр. УБ.. 2004 он.

[11]"Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээ"-ний тухай Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоол.

[12] Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт судалгааны тайлан.

Цахим гарын үсгийн талаарх нотлох баримтын талаарх ойлголтууд иргэн, эрүү, захиргааны эрх зүйд нэгэнт тогтсон зүйл хэдий ч, цахим нотлох баримт нь уламжлалт баримт бичгээс (цаасанд буулгасан баримтаас) ялгаатай тул хууль зүйн салбарт шинэ ойлголт гэж тооцогдож байна. Шүүхийн практикт мэйл хаягаар харилцсан харилцаа шүүх дээр нотлох баримтын шаардлага хангахгүй гэж үзэж байна.

Мэдээлэл технологийн хөгжил байгууллагууд, ажилтан, ажил олгогч зэрэг иргэний эрх зүйн харилцааны хэв шинжийг бүхлээр өөрчилж байна. Байгууллагууд гэрээ хэлцлийг цахимаар харилцаж, түүний үр дүнг хэлэлцэх, төлөвлөх, цахим уулзалт хийх гэх мэт бүхий л харилцаа нь цахимд суурилж байгаа боловч эрх зүйн зохицуулалтаас шалтгаалан цаасаар харилцаа давхар явагдаж, цаг хугацаа, хөрөнгө мөнгөө алдаж байна. Эрх зүйн харилцаа үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болох бүхий л шатуудад маргаан гарах эрсдэлтэй байдаг. Энэ утгаараа эрх зүйн харилцаанд үүсч буй маргааны гол нотлох баримт нь цахим баримт бичиг болж байна.

Цахим гарын үсгийн хэрэгжилт болон үр нөлөөг илүү нарийвчлан нийтийн амьдралд хүртээлтэй хүн бүрд хэрэглэх боломжийг бий болгосноор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид нотариатаар батлуулахаас бусад баримт бичгүүдэд зурсан цахим гарын үсгээ хүчин төгөлдөрт тооцуулах үндэстэй, мөн харьяалалын хувьд алслагдмал газар байгаа иргэн, захиргааны байгууллага, хуулийн этгээд гээд оролцогчид биеэр гарын үсэг зурахтай, нотлох баримтад үнэлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад илүү хялбар болох талтай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцаанд цахим гарын үсэг өөрийн хөгжил, үнэлэлт, байр суурийг тогтоож шүүхээс үнэлдэг бичмэл гарын үсэгтэй ижил тооцох хандлага дэлгэрэх юм бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд алслагдмал сум, орон нутагт ажилладаг мөрдөгч, прокурор хяналт тавихад хялбар болохоос гадна, цаг хугацаа хэмнэх зэрэг давуу талтай.

**Дүгнэлт**

Цахим гарын үсэг түүний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт сэдвээр бичсэн судалгааны ажлын явц үр дүндээ тулгуурлан судлаачийн зүгээс дараах дүгнэлтийг гаргаж байна. Цахим гарын үсгийн хамгийн өргөн хэрэглээний талбар болсон цахим худалдааг өргөн ба явцуу хүрээнд янз бүрээр тодорхойлж байна. Өргөн утгаараа текст, дуу, дүрс зэрэг өгөгдлийг цахим аргаар боловсруулж дэвшилтэт техник, технологи ашиглан интернэт орчинд дамжуулах ажиллагаанд суурилан хийгдэж буй бизнес, ажил хэрэг гэж ойлгож болохоор байна.

UNCITRAL33, OECD34, ICC35 зэрэг дэлхийн худалдааны байгууллагуудаас гаргасан загвар хууль болон зөвлөмжүүд нь цахим гарын үсэг, цахим худалдааны цахим гарын үсгийн олон улсын эрх зүйн үндэсийг бүрэлдүүлсэн бөгөөд үндэсний хууль тогтоомж хөгжих гол хөшүүрэг болж байна.

Интернэт хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаагийн хэрээр иргэд, байгууллагууд интернэтийн сүлжээг ашиглан гэрээ хэлцэл байгуулах, худалдаа үйлчилгээ эрхлэх зэргээр бизнесийн ашиг орлогоо нэмэгдүүлж байгаа өнөө үед цахим гарын үсгийн харилцааг зохицуулсан хууль нь батлагдсан ч интернэтийн сүлжээнд суурилсан хөгжил, дэвшлийн боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Мөн интернэтийн сүлжээг ашиглан хоорондоо харилцаж байсан файл, имэйлийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох эсэх нь мөн ойлгомжгүй байна. Учир нь цахим хэлбэрээр тухайн этгээд гарын үсгээ зурсан тохиолдолд тухайн гарын үсгийг ямар тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзэх эсэх нь мөн л тодорхойгүй.

Дээрх асуудлуудыг зохицуулахаар төрөөс цахим гарын үсгийг энгийн гарын үсгийн нэгэн адил хүчинтэйд тооцож баталгаажуулах, түүнийг ашиглах журмыг тодорхой болгох, тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулах шаардлага бий болсон учраас цахим гарын үсгийн тухай хуулийг батлан гаргах болсон ба эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

**Санал**

Цахим гарын үсгийн тухай эрх зүйн орчинг судалсны үндсэн дээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг[13] бий болгох ажлыг хурдасгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.
2. Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох;
3. Цахим гарын үсгийг гэрчилгээжүүлэх төрөлжсөн байгууллагыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа байгуулах шаардлагатай байна. Энэхүү байгууллага байгуулагдсанаар цахим гарын үсэг хэрэгжих үндэс бүрдэнэ. Хувийн байгууллагад эрх олгох бус, яамны харьяа байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44-р зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.19, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 101 дүгээр зүйлүүдэд тус тус цахим баримт бичиг нотлох баримтыг бичмэл нотлох баримтад оруулан үнэлэх тухай хуульчлах.
5. Цахим гарын үсгийг хэрэглэх нь эхлээд технологийн асуудал тул мэдээллийн технологийн мэргэжилтний зөвлөгөө өгөх үйлчилгээ, энэ талаар иргэдэд мэдлэг олгох зэрэг ажиллагааг хийх шаардлагатай байна. Энэ үйлчилгээг нэвтрүүлснээр цахим гарын үсгийн хэрэглээ, эрх зүйн орчин сайжрах, төр, иргэд, аж ахуйн нэгжид эдийн засгийн болон цаг хугацааны асар их хэмнэлт, үр ашгийг өгөх бололцоо бүрдэх юм.

[13] Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.11.Нийтийн түлхүүрийн дэд бүтэц гэж тоон гарын үсгийн хувийн болон нийтийн түлхүүрийг үүсгэх, зохион байгуулах, хуваарилах, хэрэглэх, хадгалах болон хүчингүй болгох, түүнийг цахим харилцаанд нэвтрүүлж ашиглахтай холбогдсон тогтолцоог хэлнэ.

**Эх сурвалжийн жагсаалт**


- Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
- Монгол Улсын Цахим гарын үсгийн тухай хууль, 2021 он
- Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоол
- Электрон Монгол үндэсний хөтөлбөр. УБ., 2004 он
- Галбаатар Л (2010) *"Цахим эрх зүй"* ,УБ, "Мөнхийн үсэг"
- Нямхүү.Ц “Домайн нэрний зүй бус ашиглалт, шийдвэрлэх арга зам"
- Рассолов. И. М. (2011), *Информационное право,* Учеб, С.3О3.
- Хуо Шу И (2012 №2-37) *Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох боломж,* (орч Мөнхтуяа Н), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 3540 дэх тал
- Халиунаа.Г(2012 №2-37) Цахим худалдааны загвар хууль батлах болсон шалтгаан, нөхцөл
- Хууль дээдлэх ёс сэтгүүл №2, УБ хот 2021 он.
- Brussels Convention on jurisdiction and Recognition of Judgments in Civil and Commercial Matters, J.O. L 299/32 (1972), amended by O.J. L 304/77 (1978), amended by O.J. L 388/1 (1982), amended by O.J. L 285/1 (1989)
- НҮБХХБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан “Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд”сэдэвт баримт бичиг
- НҮБХХБ-ын (1999.05.04) *“Цахим худалдааны эрх зүйн асуудлууд"* сэдэвт TD/B/COM.3/EM.8/2 дугаартай тайлан
- (1998) “L/ахим *худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд”,* UNCTAD/SDTE/BFB/1,87 дугаар параграф дахь нийтлэлийг
- оны 8 дугаар сарын 26 ОНДИК “Домэйн нэрийн маргаан шийдвэрлэх нэгдсэн удирдамж” 1999 оны 10 дугаар сарын 24-нд “Домэйн нэрийн маргаан шийдвэрлэх нэгдсэн удирдамжийн дүрэм”
- UNCITRAL Model Law on Electronic Commerce, http://www.uncitral.org